



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/556

Мөрөн сум

Ахмадын асрамжийн байнгын
үйлчилгээнд хамруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1.Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Даваасүрэнгийн Баатарсүх (РЭ95081919) нь төрөл садан нь харж хандах боломжгүй, ганц бие, байнгын асаргаанд байх шаардлагатай, хөдөлмөрийн чадвар алдалт 80 хувьтай иргэн тул Ахмад настны асрамж үйлчилгээний төвд 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн байнгын асрамжийн үйлчилгээнд хамруулахыг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвийн дарга (Ч.Энхбат)-д зөвшөөрсүгэй.

2.Тухайн иргэнийг аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулахыг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ